

“АВАРГА” ДЭЭД СУРГУУЛИЙН ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

Нэг: Элсүүлэх мэргэжил

“Аварга” Дээд Сургууль нь Дээд боловсролын хууль, БСШУС-ны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, 2016 оны А/87 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон “Оюутан элсүүлэх үлгэрчилсэн журам”, БСШУСЯ-ны сайдын 2021 оны 05-р сарын 20-ны өдрийн А/187 тоот “Босго оноо тогтоох тухай” тушаалыг баримтлан 4 жилийн сургалттай бакалавр зэрэгтэй дараах мэргэжлүүдээр элсүүлнэ.

1.1 Элсэлтийн бүртгэлийг хот, хөдөө орон нутагт сургуулийн элсэлтийн комисс удирдан зохион байгуулан элсүүлнэ.

1.2 *Дээд сургуульд элсүүлэх мэргэжлийн жагсаалт:*

- Спортын дасгалжуулагч – 101401 (бакалавр - өдөр),
- Багш - Биеийн тамирын боловсрол – 011410 (бакалавр - өдөр),
- Багш, сургуулийн өмнөх насны боловсрол – 011201 (бакалавр - өдөр),
- Хөдөлгөөн засалч – 091501 (бакалавр - өдөр),

Суралцах хугацаа 4 жил,

1.3 *Магистрын хөтөлбөр:*

- Багш, биеийн тамирын боловсролын– E01141001,
- Спортын дасгалжуулагч – E10110101 мэргэжлүүдээр магистрантурын элсэлтийг 10 сард, 4 сард сургууль дээр зохион байгуулна,

Суралцах хугацаа 1.5 жил,

1.4 *“Аварга” ахлах сургууль:*

- 10–12 дугаар ангийн сурагчдыг 6 сар, 8 сард элсүүлнэ.
- Дээрх мэргэжлээр бакалавр, магистр бэлтгэхийн зэрэгцээ богино хугацааны секц, дугуйлан, түр сургалт явуулна.

Хоёр. Элсэлтийн шалгуур

2.1 Монгол хэл, Нийгмийн тухай мэдлэгийн хичээлээр тэнцсэн **/босго оноо 410/** сурагчдыг элсүүлнэ;

2.2 Бие бялдын түвшин тогтоон ангийн сонголтыг чиглүүлж өгнө;

2.3 Элсэх шалгуулагчдаас ур чадварын шалгалтыг авч ерөнхий шалгалтын оноо, ур чадварын онооны дунджаар жагсаан элсүүлнэ;

“Эрүүл биетэй, саруул ухаантай амьдрах” арга ухаанд суралцаж, биеийн тамир-эрүүл мэндийн дээд боловсролтой болохыг хүссэн хүн бүхнийг манай сургуульд элсэн орж суралцахыг урьж байна!

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 хороо, Шаравын гудамж, “Аварга” ДС-ийн байр
Факс: 976-11-343392 , Утас: 342053, 344737

Утас: 91194527, 98111216, 99170996, 99147481

E-mail: avarga_ds1@yahoo.com,

Web: www.avarga.edu.mn

Гурав. Элсэхдээ бүрдүүлэх материал

- 3.1 Элсэгчдийг жил бүрийн ерөнхий шалгалтын дүн гарсан өдрөөс хойш бүртгэж, элсүүлнэ.
- 3.2 Бүртгүүлж, элсэхдээ дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
 - Тус сургуульд элсэхийг хүссэн хувийн өргөдөл;
 - Цахим үнэмлэх /хуулбар/;
 - Боловсролын үнэмлэх/12-р анги төгссөн үнэмлэх, ТМС төгссөн диплом/;
 - Хувийн хэрэг/шинэ, хуучин/;
 - Ерөнхий шалгалтанд тэнцсэн батламж;
 - 3*4 хэмжээний 4% зураг;
 - Сурлага хүмүүжил, ажил байдлын тодорхойлолт;
 - Сургалтын төлбөрийг 100% төлсөн баримт;
 - Элсэлтийн хураамж 10,000 төгрөг;

Дөрөв. Элсэлтэнд баримтлах зарчим

/Хөдөө орон нутагт МИДСХ-ны элсэлтийн зарчмыг баримтална/

- 4.1 Элсэхийг хүсэгчдийг Боловсролын Үнэлгээний Төвөөс зохион байгуулсан төгсөлтийн шалгалтын аль нэг хичээлээр батламж авсан элсэгчийг элсүүлнэ (Ерөнхий шалгалт + Ур чадварын оноо=бүгд 410–с дээш босго оноотой оюутанг элсүүлнэ).
- 4.2 Дээрх материалыг бүрдүүлж өгсөн тохиолдолд томилолт олгоно.
- 4.3 Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнд үндэслэн сургалтын төлбөрийн хөнгөлөлт:
 - 750 – 800 оноо авсан оюутны төлбөрийг 100%,
 - 700 – 749 оноо авсан оюутны төлбөрийг 50%,
 - Тив, дэлхийн медальтай тамирчинг 50% - 100%,
 - Үндэсний бөхийн аймаг, сумын цолтой бол 10% - 50%,
 - Спортын дэд мастер, спортын матер, ОУХМ бол 20% - 40%,
 - 3 найзын хамт бүртгүүлбэл – 20%,
 - 5 найзын хамт бүртгүүлбэл – 50%,
 - Багаараа элсвэл /5 ба түүнээс дээш/ – 30% тус тус хөнгөлнө,
- 4.4 Суралцах хугацаанд нь оюутны сурлага, спортын амжилтаас нь хамааруулан сургалтын төлбөрийг 10-100% хөнгөлөлт үзүүлэх болзолт тэтгэлэгтэй.
- 4.5 Сургалтын төрийн сан, Гадаад дотоодын тэтгэлэгт тусгай шалгуураар хамруулна.
- 4.6 Суралцах эрхийн бичиг хүчингүй болгосон тохиолдолд сургалтын төлбөрийн 5%-иар торгууль ноогдуулна.
- 4.7 Онлайн бүртгэлд бүртгүүлсэн тохиолдолд тухайн оюутныг элссэнд тооцно.

Тав. Элсэгчдийг бүртгэх

- 5.1 УОК, БШУЯамны шийдвэрийг үндэслэн элссэн оюутны бүртгэж хичээл сургалтын үйл ажиллагааг эхэлнэ.
- 5.2 Бүртгүүлэхдээ сургалтын төлбөрийн тооцоог бүрэн хийнэ.
- 5.3 Төрийн сангийн зээл, тусламжаар суралцах хүмүүсийн материалыг сургалт эхлэхээс 7 хоногийн өмнө хүлээн авна.

* * *